Тус байгууллага нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Засгийн газрын тогтоол, Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаал “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”, Сангийн сайдын 2021 оны 103 дугаар тушаал “Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг зохицуулах, үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд орох иргэний мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журам”, Сангийн сайдын 2021 оны 174 дүгээр тушаал “Журам, тендерийн жишиг баримт бичиг шинэчлэн батлах тухай /олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журам” зэргийг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд Төрийн албаны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Сангийн сайдын 2021 оны 102, 103 дугаар тушаалаар баталсан журмыг хүчингүй болгож шинэчилсэн зэрэг үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна.

Төсвийн шууд захирагч зарлагын гүйлгээнд гарын үсэг зурснаар дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа бол аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс холбогдох санхүүгийн баримт материал, гэрээ, гүйцэтгэлийн баримт бичгийг хянаж, зарлагын гүйлгээг хийж байна. Төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг үр нөлөөтэй гэж тодорхойлон, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэх шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дархан-Уул аймгийн ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь байгууллагын онцлог, санхүүгийн программтай нийцсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дархан-Уул аймгийн ЗДТГ 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нэмэлт өөрчлөлт ороогүй.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 595,738.4 мянган төгрөгөөр буюу 5.5 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	656,561.7	509,806.2	(146,755.5)
Урьдчилгаа	8,208.0	8,208.0	-
Бараа материал	247,279.3	204,838.0	(42,441.3)
Нөөцийн бараа	102,275.0	80,200.0	(22,075.0)
Үндсэн хөрөнгө	9,885,618.4	9,501,151.7	(384,466.7)
Нийт хөрөнгө	10,899,942.4	10,304,203.9	(595,738.4)
Өр төлбөр	1,774.9	-	(1,774.9)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	10,898,167.5	10,304,203.9	(593,963.6)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	10,899,942.4	10,304,203.9	(595,738.4)

Авлага дансны үлдэгдэл 146,755.5 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь өмнөх оны нэмэлт санхүүжилтийн дансны зарцуулагдаагүй үлдэгдэл 655,120.3 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж авлага үүсгэсэн байсныг тайлант онд авч, мөн нэмэлт санхүүжилтийн дансанд улсын болон орон нутгийн төсөв, бусад эх үүсвэрээс 143,498.7 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авч 280,110.6 мянган төгрөг зарцуулж, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн дагуу ажилчидтай холбоотой үүссэн 1,441.4 мянган төгрөгийн авлагыг барагдуулсан нь бууралтад нөлөөлжээ.

Өмнөх онд аймгийн ЗДТГ-ын 2 давхрын коридорт захиалгаар хивс хийлгэхээр 8,208.0 мянган төгрөгийг “Натурал Текстайл Групп” ХХК шилжүүлж, урьдчилж гарсан зардлаар тайлагнасан боловч тайлант онд уг ажил хийгдээгүй байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 370,788.3 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, бусад эх үүсвэрээс 100,700.0 мянган төгрөгийн нөөцийн бараа, барилгын засварын материал зэргийг үнэ төлбөргүй хүлээн авч, 482,996.6 мянган төгрөгийн бараа материал зарцуулж, 39,600.0 мянган төгрөгийн мал амьтад, 13,407.9 мянган төгрөгийн аж ахуйн бараа материалыг данснаас хассан нь бууралтад нөлөөлжээ.

Үндсэн хөрөнгө 384,466.7 мянган төгрөгөөр буурахад хуримтлагдсан элэгдлийн өсөлт голлон нөлөөлжээ. Тодруулбал тайлант онд төсвийн хөрөнгөөр 52,840.6 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил худалдан авч, ОНТХО-аар 20,000.0 мянган төгрөгийн тавилга, эд хогшил үнэ төлбөргүй хүлээн авч орлогоор бүртгэж, 457,307.2 мянган төгрөгийн элэгдэл тооцож, зардлаар хүлээн зөвшөөрсөн байна.

Өмнөх онд үүссэн 1,774.9 мянган төгрөгийн цахилгааны өр төлбөрийг барагдуулснаар тайлант онд бусдад төлөх өр төлбөргүй гарсан байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 10,304,203.9 мянган төгрөг болж 593,963.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 3,934,476.7 мянга, туслах үйл ажиллагааны орлогоос 75,000.0 мянга, нийт 4,009,476.7 мянган төгрөгийг бүрдүүлэхээр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлжээ. Төсвийн төслийн саналыг 1,726,760.5 мянган төгрөгөөр нэмж, 5,736,237.2 мянган төгрөгөөр баталсан байна. Тодруулбал өмнөх оны гүйцэтгэлд үндэслэн төрийн албан хаагчийн цалин болон бусад хууль эрхийн актад үндэслэн цалингийн зардлыг 254,942.6 мянга, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг 31,867.5 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 10,965.7 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний хөлс, төлбөр хураамжийн зардлыг 30,374.0 мянга, бараа үйлчилгээний бусад зардлыг 1,978,403.0 мянга, хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас санхүүжилтийг 12,914.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, хангамж, бараа материалын зардлыг 31,000.0 мянга, эд хогшил, урсгал засварын зардлыг 516,889.3 мянга, томилолт, зочны зардлыг 14,600.0 мянга, бусад урсгал шилжүүлгийг 30,217.0 мянган төгрөгөөр тус тус бууруулжээ.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд батлагдсан төсвийг 564,951.8 мянган төгрөгөөр бууруулж тодотгосон байна. Ингэхдээ Засгийн газрын тогтоолоор төрийн албан хаагчдын цалин нэмэгдсэнтэй холбоотой цалингийн зардлыг 475,771.5 мянга, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 60,259.9 мянга, байр ашиглалтын тогтмол зардлын тариф өссөнтэй холбоотойгоор уг зардлыг 25,439.7 мянга, хангамж бараа материалын зардлыг 42,664.7 мянга, эд хогшил, урсгал засварын зардлыг 74,517.3 мянга, томилолт зочны зардлыг 30,000.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийг 74,384.3 мянга, бусад урсгал шилжүүлгийг 17,306.4 мянган төгрөгөөр тус тус нэмж, бараа үйлчилгээний бусад зардлыг 1,365,295.6 мянган төгрөгөөр бууруулсан байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 12 арга хэмжээг санхүүжүүлэхээр 5,096,285.4 мянган төгрөг буюу 98.6 хувийг орон нутгийн төсвөөс, 75,000.0 мянган төгрөг буюу 1.4 хувийг туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 4,592,281.9 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, үндсэн үйл ажиллагааны орлогоос 55,533.1 мянган төгрөгийн орлого олжээ. Төсвийн зарлагын гүйцэтгэл 4,479,905.7 мянган төгрөг буюу 86.6 хувьтай бөгөөд зарцуулаагүй үлдсэн 86,801.8 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна. Үүнд цалингийн зардал 47,850.6 мянга, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн 20,456.9 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн 18,725.8 мянга, бараа үйлчилгээний бусад

зардал 602,317.5 мянган төгрөг тус тус зарцуулагдаагүй үлдэж, туслах үйл ажиллагааны орлого 20,908.3 мянган төгрөгөөр дутуу биелсэн нь голлон нөлөөлсөн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

		/мянган төгрөгөөр/			
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
А	"70106"-Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	5,171,285.40	4,561,013.14	(610,272.26)	86.6
1	80101"-Үндсэн үйл ажиллагааны зардал	2,142,460.40	2,095,719.77	(46,740.63)	97.8
2	80103"-Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	613,116.90	567,665.52	(45,451.38)	92.6
3	80205"-Мэдээлэл, сурталчилгааны зардал	20,000.00	20,000.00	-	100.0
4	"80219" - Харуул, хамгаалалтын зардал	6,546.00	6,546.00	-	100.0
5	" 80508"- ТББ-д төсвөөс олгох дэмжлэг	19,914.00	19,914.00	-	100.0
6	"80802"- Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	52,812.80	52,358.99	(453.81)	99.1
7	"81102"- Орон нутгийн нөөц хөрөнгө	1,246,435.30	728,808.86	(517,626.44)	58.5
8	"81507"-Мал тооллого	2,000.00	2,000.00	-	100.0
9	"81518"- Мөрийн хөтөлбөрт тусгагдсан зарим арга хэмжээг хэрэгжүүлэх	985,000.00	985,000.00	-	100.0
10	"81549"-Ахмадын сан	18,000.00	18,000.00	-	100.0
11	"82309"-Дотоодын цэргийн хамгаалалт	15,000.00	15,000.0	-	100.0
12	"82801"- Улсын их баяр наадам	50,000.00	50,000.00	-	100.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд 2022 оны нэмэлт санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдэл 655,120.3 мянга, Архивын ерөнхий газраас архивын ажилтны цалингийн санхүүжилт 23,106.3 мянга, Төрийн албаны зөвлөлөөс шалгалт зохион байгуулах зардал 5,432.0 мянга, Сангийн яамнаас сургууль, цэцэрлэгийн өвөлжилтийн бэлтгэл хангах, тоглоом худалдан авах 60,350.0 мянга, Удирдлагын академиас сургалтын зардал 9,360.0 мянга, өвсний үнийн орлого 36,890.4 мянга, оюутан цэргийн төлбөр 7,650.0 мянга, бусад эх үүсвэрээс 710.0 мянга, нийт 798,619.1 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 280,460.5 мянган төгрөг зарцуулж, зарцуулагдаагүй үлдсэн 509,806.2 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж авлагаар тусгасан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй.

Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл:

Тайлант онд бичиг хэргийн материал худалдан авах 10,000.0 мянга, багаж, техник хэрэгсэл худалдан авах 6,666.7 мянга, мэдээлэл технологийн үйлчилгээ 20,000.0 мянга, тээврийн хэрэгслийн даатгалын үйлчилгээ 6,000.0 мянга, шатахуун тосолгооны материал худалдан авах 40,000.0 мянга, шуудан, холбоо, интернэтийн үйлчилгээ 10,335.3 мянга, нийт 93,002.0 мянган төгрөгийн худалдан авах ажиллагаа зохион байгуулахаар төлөвлөгөөндөө тусгажээ. Төлөвлөгөөний дагуу харьцуулалтын аргаар 1, шууд худалдан авалтаар 5-ыг зохион байгуулсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Дархан-Уул аймгийн ЗДТГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор С.Санжаажав гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Дархан-Уул аймгийн ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 31-ны өдрийн 2-10/120 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны батлагдсан төсвийн 5,171,285.4 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 51,712.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тайлант хугацаанд төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй бөгөөд мэдээллийг бүрэн байршуулсан байв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар нийт 961,188.2 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, 957,226.6 мянган төгрөгийн 3 зөвлөмж, 3,961.6 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт өгснийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	3	957,226.6	3	957,226.6	100
Төлбөрийн акт	3	3,961.6	3	3,961.6	100
Нийт дүн	6	961,188.2	6	961,188.2	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 714,146.7 мянган төгрөгийн алдаа¹ илрүүлж аудитын явцад 3 алдааг залрууллаа. Үүнд:

1. Санхүүгийн тайланг 540,606.1 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн нь УСНББОУС-1 “Санхүүгийн тайлангийн толилуулга” стандартын 53, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдэлтэй тус тус нийцээгүй тул санхүүгийн тайлангийн эхний үлдэгдлийг залруулав.

2. Тайлант оны санхүүгийн үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан 100,700.0 мянган төгрөгийн бараа материалыг тайланд тусгаагүй байсныг тайланд залруулга хийлгэсэн.

3. Тайлант онд төсвийн хөрөнгөөр 52,840.6 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил худалдан авч, ОНТХО-аар 20,000.0 мянган төгрөгийн тавилга, эд хогшил үнэ төлбөргүй хүлээн авсныг бүртгэлд тусгаагүй байсныг бүртгэлд тусгуулж, тайланд залруулга хийлгэсэн.

Мөн аудитаар илэрсэн нийт 42,042.7 мянган төгрөгийн зөрчилд² 9,495.5 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 32,547.2 мянган төгрөгийн 4 зөвлөмж, хөрөнгийн бүртгэлд тавих хяналтыг сайжруулах, тооллогыг тогтоосон хугацаанд зохион байгуулан, үлдэгдлийг баталгаажуулж ажиллах тухай 1 албан шаардлага хүргүүлээ.

5.1 Төлбөрийн акт

- Албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2 дугаар улирлын үр дүнгийн урамшууллыг олгохдоо 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс шинэчлэгдсэн цалингаар тооцож 9,495,547.00 төгрөг илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “*батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*” гэж заасантай нийцээгүй тул төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

- Хагас жил болон жилийн эцсээр эд хөрөнгийг тооллого хийхээр ажлын хэсэг томилсон тушаал гарсан боловч тооллогын тайлан гаргаж баталгаажуулаагүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4.1-д “*эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах*”, 72.4.4-д “*комиссын хурлаар үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх*”, 73 дугаар зүйлийн 73.2-д “*Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхийн зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана*” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй тул албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж³

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

¹ Мэдээллийг тусгаагүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

³ 20.5 Шалгаагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

1. Биет бус хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тус газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй газрыг ГХБХБГ-аас авсан лавлагаатай тулган шалгахад 155,273.00 кв талбайтай 6 эзэмшлийн газрыг бүртгэлд тусгаагүй байна. Мөн нийтийн орон сууцны зориулалттай 21,440.0 мянган төгрөгийн үнэ бүхий 4,009.0 кв талбайтай 1 эзэмшлийн газрыг илүү бүртгэсэн байна. Энэ нь Газрын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.3-д заасан үүрэг, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2-д “*бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлагыг заавал бүртгэнэ*”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1-д “*Төрийн өмчийн эд хөрөнгийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан журмын дагуу үнэлж бүртгэнэ*” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Газрын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.3, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1-д заасны дагуу дээрх 6 газрыг бүртгэлд тусгах, лавлагаагаар тус байгууллагад бүртгэлгүй 1 газрыг бүртгэлээс хасах саналыг холбогдох байгууллагад хүргүүлж шийдвэрлүүлэх.

2. Урьдчилгаа данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Хивс хийлгэхээр 8,208.0 мянган төгрөг урьдчилан шилжүүлсэн боловч гүйцэтгэл байхгүй, тус байгууллагатай тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дүгээр зүйлийн 20.2.6-д “*Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах*” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дүгээр зүйлийн 20.2.6-д заасны дагуу харилцагч байгууллагатай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж байх

3. Цалингийн зардал данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Цалингийн зардлаас 3 алба хаагчид балансын урамшуулалд нийт 2,899.2 мянган төгрөг тооцож олгосон. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дүгээр зүйлийн 16.5.5-д “*Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*”, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “*Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар*”-тай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Батлагдсан төсөв, зардлын эдийн засгийн ангиллыг мөрдөж ажиллах.

4. Санхүүгийн тайлан ирүүлэхтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тус байгууллага нь 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хугацаа хоцроож буюу 2024 оны 01 дугаар сарын 31-ны өдрийн 2-10/120 тоот албан бичгээр 2024 оны 01 дугаар сарын 31-ний өдөр ирүүлсэн. Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дүгээр зүйлийн 8.9.1-д “*төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын*

байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуульд заасан хугацаанд жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг ирүүлж байх

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5⁴-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

⁴ Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Үүнээс		Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй	
							Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайланг 540,606.2 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн	1	540,606.1			1	540,606.1	1	540,606.1		
Тайлант оны санхүүгийн үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан 100,700,000.0 төгрөгийн бараа материалыг тайланд тусгаагүй байсан	1	100,700.0	1	100,700.0			1	100,700.0		
Тайлант онд төсвийн хөрөнгөөр 52,840.6 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил худалдан авч, ОНТХО-аар 20,000.0 мянган төгрөгийн тавилга, эд хогшил үнэ төлбөргүй хүлээн авсныг бүртгэлд тусгаагүй байна	1	72,840.6	1	72,840.6			1	72,840.6		
Дүн	3	714,146.7	2	173,540.6	1	540,606.1	3	714,146.7		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Зөвлөмж		Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
							Тоо	Дүн				
Шалгалтаар 4,009.0 мкв талбайтай 1 эзэмшлийн газрыг илүү, 155,273.0 мкв 6 газрыг бүртгэлд тусгаагүй байв	1	21,440.0					1	21,440.0				
Хивс хийлгэхээр урьдчилгаанд 8,208.0 мянган төгрөг шилжүүлсэн боловч гүйцэтгэл байхгүй. Тус байгууллагатай тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна	1	8,208.0					1	8,208.0				

Цалингийн зардлаас 3 алба хаагчид балансын урамшуулалд нийт 2,899.2 мянган төгрөг тооцож олгосон	1	2,899.2					1	2,899.2				
Хагас болон жилийн эцсээр эд хөрөнгийг тооллого хийхээр ажлын хэсэг томилсон тушаал гарсан боловч тооллогын тайлан гаргаж баталгаажуулаагүй байна	1	-				1	-					
Тус байгууллага нь 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 2024 оны 01 дугаар сарын 31-ны өдрийн 2-10/120 тоот албан бичгээр 2024 оны 01 дугаар сарын 31-ны өдөр ирүүлсэн.	1	-					1	-				
Албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2 дугаар улирлын үр дүнгийн урамшууллыг олгохдоо 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс шинэчлэгдсэн цалингаар тооцож 9,495,547.00 төгрөг илүү олгосон байна	1	9,495.5	1	9,495.5								
Дүн	6	42,042.7	1	9,495.5	1	-	4	32,547.2				